

СҮХБААТАР АЙМАГ

Малын зөөврийн хашааны техникийн тодорхойлолт

Дугуйт чиргүүл бүхий зөөврийн хашаа нь 500-600 богийн багтаамжтай, зэврэлтээс хамгаалагдсан бат бөх төмрөөр гагнагдаж хийгдсэн байна.

Зөөврийн хашааг бага оврын суудлын машинаар хаана ч зөөвөрлөн аваачиж болох бөгөөд нэг хүн 20-30 минутын дотор угсарч, задлах ажлыг гүйтэтгэж чадахаар байна.

Дугуйт чиргүүл бүхий зөөврийн хашаа нь Хашлага, Хүзүүвч хашлага, Хаалга, Явах анги зэргээс бүрдэнэ.

- **Хашлага** - 30 ширхэг (1,6 м x 1,1 м)
20 мм труба, 20 мм квадрат төмрөөр гагнаж хийсэн, 1,1 метр өндөртэй, 1,6 метр урттай, сараалж хоорондын зай нь 13-14 см 8 ширхэг төмөртэй, сараалж хоорондыг холбох 4 ширхэг сэнжтэй, 1,1 метр урт 14 мм холбоос төмөртэй байна. Хашлагуудыг өөр хооронд нь хялбархан холбох өөр шинэ аргыг ашиглаж болно.
- **Хүзүүвч хашлага** – (2 м x 1,1 м) Хүзүүвч хашлага нь хашааг зөөж тээвэрлэхэд бусад хашааг дээр нь тавьж зөөх дугуйт чиргүүлийн арал болох бөгөөд хашааг дэлгэн угсрах үед хашааны үндсэн холболтын хэсэг болох тул бат бөх, зузаан төмрөөр хийгдсэн байна. Чиргүүлийн гарыг хүзүүвч хашлага буюу чиргүүлийн аралнаас салгах, аралд угсрахад маш энгийн, хялбар хийцтэй байх шаардлагатай. Хонийг ялгах, цувраа байрлалд оруулах нарийсгасан хүзүүвч хэсэгтэй. Энэ хэсэгт хонийг ангилан ялгахад хялбар болгосон (1,2 м x 1,1 м), (0,6 м x 1,1 м) хэмжээтэй 2 хаалгатай байна.
- **Хаалга** - (2,0 м x 1,1 м) Хаалга нь хашлага хэсгүүдтэй холбогдох бөгөөд хаалгыг нээх, хаах хялбаршуулсан түгжээтэй байна.
- **Явах эд анги** – Зөөврийн хашааны чиргүүлийн дугуй нь 185 R 15 хэмжээтэй 4 улирлын шинэ дугуй байна. Хүзүүвч хашлага буюу чиргүүлийн аралтай дугуйг холбож угсрахад хялбар байна.

Жич: Техникийн тодорхойлолттой холбоотой лавлах зүйл байвал Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн албаны дарга Молорчимэгтэй 99082688 дугаарын утсаар холбогдоно уу.

Зураг 1. Хашлага, Хүзүүвч хашаа



Зураг 2. Хүзүүвч хашлага буюу чиргүүлийн арал



Зураг 3. Явах эд анги



Зураг 4. Хаалга

